## ХУРАЛДААНЫ ТОЙМ

## ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛИЙН
## 2015 ОНЫ АРВАН ХОЁРДУГААР ХУРАЛДААН

Хуралдаан 2015 оны дөрөвдүгээр сарын 2-ны 14 цаг 04 минутад эхэлж, 15 цаг 20 минут хүртэл Төрийн албаны зөвлөлийн хуралдааны танхим (Засгийн газрын 11 дүгээр байрны 301 тоот өрөө)-д болж, нийт 1 цаг 16 минут үргэлжлэв.

| № | Хэлэлцсэн асуудал | Гарсан шийдвэр |
|---|---|---|
| 1 | Аж үйлдвэрийн яамны зарим газрын даргын албан тушаалд томилуулахаар Төрийн албаны зөвлөлийн дүгнэлт гаргаж, нэр дэвшүүлэх тухай<br>- Хүнд үйлдвэрийн бодлогын газрын даргын албан тушаалд томилуулах<br>- Худалдааны бодлого зохицуулалтын газрын даргын албан тушаалд томилуулах<br>- Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газрын даргын албан тушаалд томилуулах | Төрийн албаны тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1, 35 дугаар зүйлийн 35.1.6 болон Улсын Их Хурлын 2003 оны 13 дугаар тогтоолоор баталсан “Төрийн жинхэнэ албаны удирдах албан тушаалд томилогдох ажилтныг сонгон шалгаруулах журам”-ын 14-ийн “а”-д заасныг тус тус баримталж, Төрийн албаны зөвлөлийн 2015 оны 04 дүгээр 02-ны өдрийн хуралдааны шийдвэрийг үндэслэн:<br>Дашбалжирын Нэмэхбаярыг Аж үйлдвэрийн яамны Хүнд үйлдвэрийн бодлогын газрын даргын албан тушаалд томилуулахаар дүгнэлт гарган нэр дэвшүүлж, Аж үйлдвэрийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Д.Нямхүүд санал болгох тухай Монгол Улсын Төрийн албаны зөвлөлийн тогтоол гаргахаар тогтов.<br><br>Төрийн албаны тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1, 35 дугаар зүйлийн 35.1.6 болон Улсын Их Хурлын 2003 оны 13 дугаар тогтоолоор баталсан “Төрийн жинхэнэ албаны удирдах албан тушаалд томилогдох ажилтныг сонгон шалгаруулах журам”-ын 14-ийн “а”-д заасныг тус тус баримталж, Төрийн албаны зөвлөлийн 2015 оны 04 дүгээр сарын 02-ны өдрийн хуралдааны шийдвэрийг үндэслэн:<br>Батсуурийн Золтуяаг Аж |

| | | |
|---|---|---|
| | | үйлдвэрийн яамны Худалдааны бодлого, зохицуулалтын газрын даргын албан тушаалд томилуулахаар дүгнэлт гарган нэр дэвшүүлж, Аж үйлдвэрийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Д.Нямхүүд санал болгох тухай Монгол Улсын Төрийн албаны зөвлөлийн тогтоол гаргахаар тогтов.<br><br>Төрийн албаны тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1, 35 дугаар зүйлийн 35.1.6 болон Улсын Их Хурлын 2003 оны 13 дугаар тогтоолоор баталсан “Төрийн жинхэнэ албаны удирдах албан тушаалд томилогдох ажилтныг сонгон шалгаруулах журам”-ын 14-ийн “а”-д заасныг тус тус баримталж, Төрийн албаны зөвлөлийн 2015 оны 04 дүгээр сарын 2-ны өдрийн хуралдааны шийдвэрийг үндэслэн:<br>Төгсийн Энхбаярыг Аж үйлдвэрийн яамны Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газрын даргын албан тушаалд томилуулахаар дүгнэлт гарган нэр дэвшүүлж, Аж үйлдвэрийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Д.Нямхүүд санал болгох тухай Монгол Улсын Төрийн албаны зөвлөлийн тогтоол гаргахаар тогтов. |
| 2 | Сангийн яамны зарим газрын даргын албан тушаалд томилуулахаар Төрийн албаны зөвлөлийн дүгнэлт гаргаж, нэр дэвшүүлэх тухай<br>- Эдийн засгийн бодлогын газрын даргын албан тушаалд томилуулах<br>- Хөгжлийн санхүүжилт, өрийн удирдлагын газрын даргын албан тушаалд томилуулах<br>- Төрийн сангийн газрын даргын албан тушаалд томилуулах | Төрийн албаны тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1, 35 дугаар зүйлийн 35.1.6 болон Улсын Их Хурлын 2003 оны 13 дугаар тогтоолоор баталсан “Төрийн жинхэнэ албаны удирдах албан тушаалд томилогдох ажилтныг сонгон шалгаруулах журам”-ын 14-ийн “а”-д заасныг тус тус баримталж, Төрийн албаны зөвлөлийн 2015 оны 04 дүгээр сарын 02-ны өдрийн хуралдааны шийдвэрийг үндэслэн:<br>Галсандоржийн Батхүрэлийг Сангийн яамны Эдийн засгийн бодлогын газрын даргын албан тушаалд томилуулахаар дүгнэлт гарган нэр дэвшүүлж, Сангийн яамны Төрийн нарийн |

| | | |
|---|---|---|
| | | бичгийн дарга Х.Ганцогтод санал болгох тухай Монгол Улсын Төрийн албаны зөвлөлийн тогтоол гаргахаар тогтов.<br><br>Төрийн албаны тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1, 35 дугаар зүйлийн 35.1.6 болон Улсын Их Хурлын 2003 оны 13 дугаар тогтоолоор баталсан “Төрийн жинхэнэ албаны удирдах албан тушаалд томилогдох ажилтныг сонгон шалгаруулах журам”-ын 14-ийн “а”-д заасныг тус тус баримталж, Төрийн албаны зөвлөлийн 2015 оны 04 дүгээр сарын 02-ны өдрийн хуралдааны шийдвэрийг үндэслэн:<br>Батсэнгээгийн Доржсэмбээг Сангийн яамны Хөгжлийн санхүүжилт, өрийн удирдлагын газрын даргын албан тушаалд томилуулахаар дүгнэлт гарган нэр дэвшүүлж, Сангийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Х.Ганцогтод санал болгох тухай Монгол Улсын Төрийн албаны зөвлөлийн тогтоол гаргахаар тогтов.<br><br>Төрийн албаны тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1, 35 дугаар зүйлийн 35.1.6 болон Улсын Их Хурлын 2003 оны 13 дугаар тогтоолоор баталсан “Төрийн жинхэнэ албаны удирдах албан тушаалд томилогдох ажилтныг сонгон шалгаруулах журам”-ын 14-ийн “а”-д заасныг тус тус баримталж, Төрийн албаны зөвлөлийн 2015 оны 04 дүгээр сарын 02-ны өдрийн хуралдааны шийдвэрийг үндэслэн:<br>Санжаагийн Наранцогтыг Сангийн яамны Төрийн сангийн газрын даргын албан тушаалд томилуулахаар дүгнэлт гарган нэр дэвшүүлж, Сангийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Х.Ганцогтод санал болгох тухай Монгол Улсын Төрийн албаны зөвлөлийн тогтоол гаргахаар тогтов. |

| | | |
|---|---|---|
| 3 | Төрийн албаны зөвлөлийн Аж үйлдвэрийн яамны дэргэдэх Салбар зөвлөлийн дарга, нарийн бичгийн даргыг томилох | Улсын Их Хурлын 2009 оны 87 дугаар тогтоолоор баталсан "Төрийн албаны зөвлөлийн үйл ажиллагааны дүрэм"-ийн 3.3, Аж үйлдвэрийн сайдын 2015 оны 03 дугаар сарын 24-ны өдрийн 01/685 тоот албан бичгээр ирүүлсэн хүсэлт, Төрийн албаны зөвлөлийн 2015 оны 04 дүгээр сарын 02-ны өдрийн хуралдааны шийдвэрийг үндэслэн:<br>1. Төрийн албаны зөвлөлийн Аж үйлдвэрийн яамны дэргэдэх салбар зөвлөлийн даргаар тус яамны Төрийн нарийн бичгийн дарга Даваагийн Нямхүүг 2015 оны 04 дүгээр сарын 02-ны өдрөөс эхлэн томилох<br>2. "Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлийн ажиллах журам"-д заасан чиг үүргийг хууль тогтоомжийн хүрээнд бүрэн хэрэгжүүлж ажиллахыг Салбар зөвлөлийн дарга Д.Нямхүүд үүрэг болгох тухай Монгол Улсын Төрийн албаны зөвлөлийн тогтоол гаргахаар тогтов.<br><br>Улсын Их Хурлын 2009 оны 87 дугаар тогтоолоор баталсан “Төрийн албаны зөвлөлийн үйл ажиллагааны дүрэм”-ийн “Гурав”-ын 3.3, Аж үйлдвэрийн сайдын 2015 оны 03 дугаар сарын 24-ний өдрийн 01/685 тоот албан бичгээр ирүүлсэн хүсэлт, Төрийн албаны зөвлөлийн 2015 оны 04 дүгээр сарын 02-ны өдрийн хуралдааны шийдвэрийг үндэслэн:<br>1. Төрийн албаны зөвлөлийн Аж үйлдвэрийн яамны дэргэдэх Салбар зөвлөлийн нарийн бичгийн даргаар тус яамны Төрийн захиргааны удирдлагын газрын Хүний нөөц хариуцсан мэргэжилтэн Эрдэнэбатын Ундралыг 2015 оны 04 дүгээр сарын 02-ны өдрөөс эхлэн томилох<br>2. "Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлийн ажиллах журам"-д заасан чиг үүргийг хууль тогтоомжийн |

| | | |
|---|---|---|
| | | хүрээнд бүрэн хэрэгжүүлж ажиллахыг Салбар зөвлөлийн нарийн бичгийн дарга Э.Ундралд үүрэг болгох тухай Монгол Улсын Төрийн албаны зөвлөлийн тогтоол гаргахаар тогтов. |
| 4 | Төрийн албаны зөвлөлийн Баянхонгор аймаг дахь Салбар зөвлөлийн нарийн бичгийн даргыг томилох тухай | Улсын Их Хурлын 2009 оны 87 дугаар тогтоолоор баталсан "Төрийн албаны зөвлөлийн үйл ажиллагааны дүрэм"-ийн "Гурав"-ын 3.3, Баянхонгор аймаг дахь Салбар зөвлөлийн даргын 2015 оны 03 дугаар сарын 23-ны өдрийн 57 тоот албан бичгээр ирүүлсэн хүсэлт, Төрийн албаны зөвлөлийн 2015 оны 04 дүгээр сарын 02-ны өдрийн хуралдааны шийдвэрийг үндэслэн:<br>1. Төрийн албаны зөвлөлийн Баянхонгор аймаг дахь Салбар зөвлөлийн нарийн бичгийн даргаар тус аймгийн Засаг даргын Тамгын газрын Хүний нөөцийн асуудал хариуцсан мэргэжилтэн Болдбаатарын Биндэръяаг 2015 оны 04 дүгээр сарын 02-ны өдрөөс эхлэн томилох<br>2. Төрийн албаны зөвлөлийн 2013 оны 141 дүгээр тогтоолын 2 дугаар хавсралтын "Хоёр"-ын 3-т "....Тамгын газрын дарга Осрондамбын Тойвгоо" гэсний дараа "нарийн бичгийн дарга–Аймгийн Засаг даргын Тамгын газрын Төрийн захиргаа, удирдлагын хэлтсийн хүний нөөцийн асуудал хариуцсан мэргэжилтэн Болдбаатарын Биндэръяа" гэж нэмэх.<br>3. "Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлийн ажиллах журам"-д заасан чиг үүргийг хууль тогтоомжийн хүрээнд бүрэн хэрэгжүүлж ажиллахыг Салбар зөвлөлийн нарийн бичгийн дарга Б.Биндэръяад үүрэг болгох тухай Монгол Улсын Төрийн албаны зөвлөлийн тогтоол гаргахаар тогтов. |

**ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛ**